

БАГШ НАРЫН ХӨГЖЛИЙНХӨӨ ХЭРЭГЦЭЭГ ТОДОРХОЙЛСОН СУДАЛГААНД ХИЙСЭН АНАЛИЗ

Ч.Байгалмаа

МУБИС-ийн Боловсрол Судлалын сургууль

Summary

In the frame of the project “Outreach” which is being implemented by MSUE, Exeter University of England, International Educational Development Centre, Denmark, the survey was done among the teachers to be involved in the project and an analysis was also made on the survey materials. The project includes result of the survey aimed at determining needs of the teacher development.

Outreach төслийн үндсэн багийн гишүүд

1. Ц.Батсуурь МУБИС-ийн проректор, проф
2. С.Батхуяг Босс-ийн СХУ-тэнхмийн эрхлэгч, проф PhD
3. Ч.Пүрэвдорж МУБИС-ийн БУТ-ийн эрхлэгч, проф ScD
4. Ц.Бурмаа ГХС-ийн АХАЗТ-ийн эрхлэгч, докторант
5. Д.Өнөрчимэг ГХС-ийн АХАЗТ-ийн багш, докторант
6. Д.Нармандах ГХС-ийн АХАЗТ-ийн багш, докторант
7. Д.Баярлах БТС-ийн ХАТ-ийн эрхлэгч, докторант
8. А.Бямба БУС-ийн багш, дэд проф PhD
9. Я.Шийлэгмаа ТНУС-ийн багш, докторант
10. Х.Чинтогтох Хэнтий БСГ-ын аргазүйч, бакалавр
11. Т.Пүрэвсүрэн Төв БСГ-ын аргазүйч, бакалавр
12. Д.Цэдэвсүрэн КМТС-ийн ПДТ-ийн эрхлэгч, докторант
13. Т.Энхтуяа Багшийн Коллежийн багш, докторант
14. О.Алтангоо ФТС-ийн ФТ магистр
15. Л.Жумдаан МоСС-ийн МХШТ-ийн багш, PhD
16. Л.Даваажаргал МаСС-ийн тэнхмийн эрхлэгч, магистр
17. А.Энхмаа ДУТС-ийн багш, PhD

Хураангуй

Энэхүү илтгэлд МУБИС, Английн Эксэтэрийн Их Сургууль, Данийн ОУ-ын боловсролын хөгжлийн төв хамтран хэрэгжүүлж буй “Outreach” төсөлд хамрагдах багш нараас авсан судалгааны материалд анализ хийн багш хөгжлийнхөө хэрэгцээг тодорхойлж байгааг судалсан судалгааны үр дүнг танилцуулна.

Түлхүүр үгс

Багшийн хөгжил - Мэргэжлийн онол аргазүйн мэдлэг, зан үйл, биеэ авч явах байдал, бусадтай харилцах харилцаа, хандлага, сэтгэлгээ, ур чадвар, эвдүй зэрэгт дэвших хандлагатай өөрчлөлт гарч хөгжих үйл явц.

- **Хөгжлийн хэрэгцээ** - Хөгжихөд шаардагдаж буй гачигдал байдлаар тодорхойлсон
- **Багш боловсрол** - Багшлахад хэрэглэгдэх чадваржсан МЭДЛЭГ
- **Багш боловсролын чанар** - Мэргэжлийн ажил гүйцэтгэх МЭДЛЭГ, арга барил, ур чадвар, эв дүйд үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж, боловсролын стандартын биелэлт, ТӨГСӨГЧДИЙН ажил амьдралд бэлтгэгдсэн байдал.
- **Сэтгэлгээ** - СЭТГЭж буй байдал, СЭТГЭЛЭГ [Я.ЦЭВЭЛ МОНГОЛ ХЭЛНИЙ ТОВЧ тайлбар толь 506-р хуудас]

Үндэслэл. ЕБС-ийн багш нар мэргэжил дээшлүүлэх чиглэл, хэрэгцээгээ нарийн тодорхойлдоггүй, төвлөрсөн сургалт семинарт оролцох төдийгөөр хязгаарлах байдал ажиглагдсаныг үндэслэн хөгжлийн хэрэгцээг хэрхэн тодорхойлж байгааг тодруулах үүднээс судалгаанд анализ хийв.

Зорилго. ЕБС-ийн багш нарын хөгжлийн хэрэгцээгээ тодорхойлсон судалгаанд, анализ хийн дүгнэлт гаргах.

Зорилт

- Багш нараас авсан судалгааны материалыг нэгТГЭХ
- Нэгтгэсэн материалд боловсруулалт хийх
- Судалгааны үр дүнг тооцох, дүгнэлт гаргах


Судалгааны арга. Асуулга

- Баримт бичиг судлах
- Математик боловсруулалт


Хамрах хүрээ.

Төв, Хэнтий аймгийн ЕБС-ийн 203 багш

График№1



Диаграмм №2




Багш хөгжлийнхөө хэрэгцээг тодорхойлсон байдлын судалгаанд хийсэн анализ. Төв аймгийн 97, Хэнтий аймгийн 106, нийт 203 багшаас ХӨГЖЛИЙНХөө хэрэгцээ, чиглэлийг тодорхойлж байгаа байдлыг илрүүлэх зорилгоор 2006 оны 3-р сард асуулгын аргаар судалгаа авч өөрийгөө хөгжүүлэх чиглэлээ тодорхойлсон байдлыг нь илрүүлэхийг зорилоо. .

- **Та ямар чиглэлээр өөрийгөө хөгжүүлэхийг хүсч байна вэ?** асуултыг тавьж хариултыг НЭЭЛТГЭЙ авсан. Багш хөгжих чиглэлийн нэрийг заасан бол ерөнхий, хөгжих чиглэлийн нэр, СЭДЭВ заасан бол тодорхой гэж үзсэн. Өөрийн хөгжих чиглэлийг ерөнхий байдлаар тодорхойлсон 117 багш буюу судалгаанд хамрагдагчдын 58%, тодорхой 78 багш 38%. толорхойлоогүй 9 багш 4%. Үүнээс үзвэл нийт багш нарын 38% өөрийнхөө хөгжлийн чиглэлийг тодорхой байдлаар тодорхойлж үлдсэн 62% ямар чиглэлээр хөгжих хэрэгцээтэй байгаагаа сайн мэдэхгүй байдал харагдаж байна.

- **Ямар зорилгоор хөгжих хэрэгтэй вэ?** ГЭДгийг нь эсээ бичсэн байдалд ч үнэлгээ өгч илрүүлсэн. ҮНЭЛГЭЭ ӨГӨХДӨө ерөнхий, оновчтой гэсэн шалгуур гарган үнэлсэн юм. Ерөнхий гэсэн шалгуурт ХӨГЖЛИЙн ач холбогдлыг судлагдхуун, ХИЧЭЭЛЭэр заасан бол оновчтой . ГЭДЭГТ нь өөрт, сурагчидад, сургуульд ямар хэрэгтэйг тодорхойлсон байдлаар авч үзлээ Ерөнхий байдлаар тодорхойлсон 94 багш буюу судалгаанд оролцогчдын 46%, Оновчтой байдлаар тодорхойлсон 67багш судалгаанд оролцогчдын 33%, Тодорхойгүй 42 багш-21% Үүнээс үзвэл нийт багш нарын 33% нь өөрийн хөгжлийн зорилгыг оновчтой тодорхойлж 67% ХӨГЖЛИЙНХөө ач холбогдол, зорилгыг тодорхойлоогүй байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм

- **Эсээ бичлэгийн чанар.** Үгийн тоо дунджаар 203 байв. Эсээ бичсэн 199 багш (98%) бичээгүй-4 багш (2%)
- **Тулгамдаж байгаа асуудал, бэрхшээлийг тодорхойлсон байдал.**1-3 оноо өгсөн.
 - СХ-лэх ажилд тулгамдсан асуудлаа үндэслэлтэй гаргасан - (3 оноо)
 - Тулгамдаж байгаа бэрхшээлийн шалтгааныг бичээгүй - (2 оноо)
 - Тулгамдаж байгаа асуудал болон шалтгааныг дутуу гаргасан - (1 оноо)
 - Тулгамдаж байгаа асуудал болон түүний шалтгааныг огт дурдаагүй бол (0 оноо) тус тус өгч ҮНЭЛСЭН. 3 оноог 39 багш (19%), 2 оноог 97 багш (48%), 1 оноог 62 багш (30.5%),0 оноог 5 багш (2.5%), Онооны нийлбэр 418, онооны дундаж 2 буюу хувиар илэрхийлбэл хийлбэл 66.6% байна.

График №3



- **Түлгэмдсэн асуудлаа шийдвэрлэх арга зам хайсан байдалд** нь 1-3 оноо өгсөн
 - Арга замаа оновчтой сонгон хэрэгжүүлэх аргыг зааж өгсөн бол (3 оноо)
 - Арга замаа ерөнхий заасан бол (2 оноо)
 - Шийдвэрлэх талаар дурдсан боловч хэрэгжүүлэх арга бичээгүй бол (1 оноо)
 - Энэ тухай огт дурдаагүй бол (0 оноо) өгч үнэлсэн.

3 оноог 17 багш (8%), 2 оноог 79 багш (39%), 1 оноог 73 багш (36%) 0 оноог 34 багш (17%) тус үзүүлж онооны нийлбэр 282. Онооны дундаж 1.3 хувиар илэрхийлбэл 43.3%.
- **Түлгэмдаж байгаа бэрхшээлийг шийдвэрлэхэд өөрийн оролцоог тодорхойлсон байдалд** 1-3 оноо өгсөн.
 - Бэрхшээлийг шийдвэрлэхэд өөрийн оролцоог тодорхой нарийн гаргасан (3 оноо)
 - Асуудлыг шийдвэрлэхэд өөрийн оролцоог тодорхой бус ерөнхий бичсэн бол (2 оноо)
 - Оролцоог дутуу бичсэн бол (1 оноо)
 - Оролцоог огт бичээгүй бол (0 оноо) өгч үнэлсэн.

3 оноог 18 багш (9%), 2 оноог 28 багш (14%), 1 оноог 73 багш (36%), 0 оноог 4 багш (2.0%) тус тус үзүүлэв. Онооны нийлбэр 177, онооны дундаж 0.9 хувиар илэрхийлбэл 30% байна.
- **Бэрхшээлийг шийдвэрлэснээр гарах үр дүнг тодорхойлсон байдалд** 1-3 оноо өгсөн.
 - Асуудлыг шийдвэрлэснээр гарах үр дүнг оновчтой тодорхойлсон бол (3 оноо)
 - Үр дүнг оновчтой бус тодорхойлсон бол (2 оноо)
 - Үр дүнг буруу болон дутуу гарган бичсэн бол (1 оноо)
 - Үр дүнгийн тухай огт бичээгүй бол (0 оноо) өгч үнэлсэн.

3 оноог 14 багш (7%), 2 оноог 48 багш (24%), 1 оноог 74 багш (36%), 0 оноог 67 багш (33%) тус тус үзүүлэв. Онооны нийлбэр 212, Онооны дундаж 1.0 хувиар илэрхийлбэл 33.3% байв.
- **Гарах үр дүнгийн нөлөө ач холбогдолд** 1 - 3 оноо өгсөн.
 - Хичээлд, сурагчдад, сургалтын орчинд, сургуулийн үйл ажиллагаанд нөлөөлөх нөлөөллийг бичсэн бол (3 оноо)
 - Дээрхи заасан нөхцөлүүд дутуу бол (2 оноо) бичээгүй бол (1 оноо) –
 - Хичээлд, сурагчдад, сургалтын орчинд сургуулийн үйл ажиллагаанд нөлөөлөх нөлөөллийг мичээгүй бол (1 оноо)

- Үр дунгийн ач холбогдлыг огт бичээгүй 0 оноог өгч үнэлсэн. 3 оноог 13 багш (6%), 2 оноог 36 багш (18%). 1 оноог 82 багш (40%). 0 оноог 12 багш, (5670) с тус авав. Онооны нийлбэр 193, Онооны дундаж 0.9, хувиар илэрхийлбэл 30% байна.

Дүгнэлт

Дээрх судалгаанд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

Судалгаанд хамрагдсан багш нарын 62% ямар чиглэлээр хөгжихөө, 67% нь хөгжихийн зорилго буюу хэрэгцээ юунд оршиж байгааг тодорхойлоогүй нь сурган хүмүүжүүлэх ажилдаа өөрийн үнэлгээ дүгнэлт хийдэггүй, хөндлөнгийн үнэлгээнд найдаж явдгаас бүтээлч сэтгэлгээ, болон мэргэжлийн бие даасан байдал нь өнөөгийн нийгмийн хөгжлийн хэрэгцээ шаардлагын түвшингээс хоцрогдонгүй байна. .

Бэрхшээлийг шийдвэрлэх арга зам, чөлөөт эрэл хайгуул, хийдэггүй, өөрийн гүйцэтгэх байр суурийг тодорхойлоход анхаарал бага хандуулдаг нь практик үйл ажиллагаандаа шүүмжлэлтэй хандах, арга барил (reflection)-д суралцаагүй, үйл ажиллагаандаа хэвшүүлээгүйгээс шалтгаалж байна.

Асуудал шийдвэрлэснээр гарах үр дүнг хангалттай тодорхойлохгүй байгаа нь асуудалд гүйцэтгэгч байр сууринаас ханддаг өмнөх нийгмийн сэтгэлгээнээс салаагүй, хандлага арга барил нь шинэчлэгдэхгүй байгаагаар шууд холбогдоно.

Эдгээрээс үндэслэн эцэст нь дүгнэхэд багшийн сэтгэлгээний шинэчлэлт удаашралтай байгаад анхаарлаа хандуулан багш нар үйл ажиллагаанаас суралцахын тулд үйлийн судалгааг (action reseach) сурган хүмүүжүүлэх ажилдаа хэрэгжүүлэх шаардлагатай байна.